

ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б.БАЯРЧИМЭГ



ШҮДНИЙ ИХ ЭМЧИЙН
“ШҮДНИЙ ТУЛГУУР ЭД СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r) 091107

ХУГАЦАА: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ

АЖЛЫН ХЭСЭГ:

- Б. Баярчимэг Нүүр ам судлалын сургуулийн Шүдний төв эмнэлгийн Шүдний тулгуур эд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, дэд профессор
- Х. Оюунхишиг Нүүр ам судлалын сургуулийн Шүдний төв эмнэлгийн Шүдний тулгуур эд судлалын тэнхимийн багш

МОНГОЛЫН ШҮДНИЙ ТУЛГУУР ЭДИЙН ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛӨЛ:

- Д. Баярчимэг, Глобалдент шүдний эмнэлгийн захирал

ХЯНАСАН:

- Н.Дашдондов Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Д. Дондогмаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

ШҮДНИЙ ИХ ЭМЧИЙН “ШҮДНИЙ ТУЛГУУР ЭД СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Шүдний тулгуур эдийн өвчин нь шүд цоорох өвчний дараа орох хамгийн өндөр тархалттай өвчин юм. Дэлхийн хүн амын 20-50%-ийг хамарсан өндөр тархалттай тохиолддог олон шалтгаант архаг халдварт өвчин бөгөөд шүдгүйдэлд хүргэдэг үндсэн шалтгаан юм. Энэ өвчин нь шүдийг тулан тогтоож байгаа эд эрхтнийг эвдрэлд хүргэдэг үрэвсэлт өвчин бөгөөд өвөрмөц нянгаар үүсгэгдэж шүдний холбоос эд, түүшин ясыг эрчимтэй эвдлэн шүд буйлны эмгэг хөндий үүсэх, буйл шамрахад хүргэдэг. Шүдний тулгуур эдийн өвчний улмаас зажлах, хоол боловсруулах эрхтний үйл ажиллагаа хямрах төдийгүй нийгэмтэй харилцах өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, амьдралын чанар буурахад хүргэдэг. Түүнчлэн гүйлсэн булчирхайн үрэвсэл, зүрх судас, үе мөч, бөөрний өвчин, дутуу төрөлт, бага жинтэй хүүхэд төрөх, алцгеймерийн өвчин зэрэг бие махбодийн бусад өвчин, эмгэг үүсэхэд хүргэдэг байна.

Манай оронд шүдний тулгуур эдийн төлөвийг анх 1974 оноос судалж эхэлсэн ба энэ талаар хийгдсэн манай судлаачдын үр дүнгээс харахад (Д. Сэлээ 1974, Ц. Норовпил 1983, Б. Оюунбат 1993, Ц. Батцэцэг 1996, Х. Цолмон 1998, Д. Одонтуяа 2009, С. Оюунсайхан 2009) шүдний тулгуур эдийн өвчний тархалт хүүхэд залуучуудад буйлны үрэвслээр эхэлж нас ахих тусам шүд сулрахад хүргэж, эмчилгээний шаардлага ч уялдан ихсэх хандлагатай байгааг дурджээ. Монгол улсын хэмжээнд 2013 онд хийгдсэн анхны үндэсний хэмжээний судалгааны үр дүнгээр шүдний тулгуур эдийн өвчний тархалт монгол хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд өндөр (71.1%) байгааг тодорхойлсон байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд буйлны цус гаралт, шүдний чулуу зэрэг үзүүлэлтүүд давамгайлж байв. Тухайлбал, 5 настай хүүхдүүдийн 34.8%, 12 настай хүүхдүүдийн 58.1%, 15 настай шилжилтийн насны хүүхдүүдийн 73%, 18 настнуудын 64.9%, 35-44 настай хүмүүсийн 62.9%, 65-74 настай хүмүүсийн 56.4% дээрх үзүүлэлттэй байжээ. Нас ахих тутам буйлны цус гаралт, шүдний чулуутай хүмүүсийн тоо ихсэж 18 наснаас эхэлж буйл шүдний эмгэг хөндий ажиглагдаж гүехэн хэмжээнээс 35-44 насанд гүн эмгэг хөндийтэй болж байв. Түүнчлэн авагдсан шүдний тоо нас ахих тусам нэмэгдэн 35-44, 65-74 насны бүлгүүдэд бүрэн шүдтэй хүний эзлэх хувь эрс багасаж, авагдсан шүдний тоо дунджаар 17.2 хүртэл өсөж байв.

Б. Цолмонцацрал нарын (2015) судалгаагаар зүрхний ишеми өвчин оношлогдсон хүмүүсийн 86%-д буйл шүдний эмгэг хөндий илэрсэн байхад эрүүл хүмүүсийн дунд 41%-тай байжээ. Энэ судалгаагаар эмгэг хөндийн хэмжээ ихсэхэд зүрх судасны өвчний эрсдэл бусад лабораторын болон шүдний тулгуур эдийн үзүүлэлтээс хамааран 2.75 – 3.49 дахин нэмэгдэж байгаа төдийгүй буйл шүдний эмгэг хөндийн гүн >3мм бүхий хөндийн тоо зүрх судасны өвчинтэй хамааралтай (OR1.24 (95%CI:1.03, 1.5)) болох нь харагдаж байв.

Шүдний тулгуур эдийн байдал нүүр амны согог засал, нүүр амны гажиг засал, нүүр амны гоо сайхан зэрэг бусад салбарын эмчилгээний төлөвлөлт, тавиланд нөлөөлөх гол хүчин зүйл юм.

Олон улсад бие даасан салбар болох шүдний тулгуур эд судлалын салбарыг хөгжүүлэхэд 2006 оноос хойш Япон, БНСУ, АНУ, Хонгконг, Тайван, Куба зэрэг гадаадын их дээд сургуулиуд, эмнэлгүүдэд тасралтгүй сургалтанд хамрагдаж 2009 оноос хойш Олон улсын Шүдний тулгуур эдийн мэргэжлийн эмч нарын холбоо нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж Австри, БНСУ, Куба улсаас нарийн мэргэжлийн эмч нарыг урьж монголын эмч нартаа тасралтгүй гар дадлагатай сургалтуудыг хийж ирсэн. Хоёр холбооны хамтын ажиллагааны хүрээнд 2011 оноос хойш Солонгосын Шүдний тулгуур эдийн академийн гишүүд болох их сургуулиудын Шүдний тулгуур эдийн тэнхмийн профессорууд НАСС-ийн хичээлийн байр болон БНСУ-ын Сеулийн Их сургууль, Кюунг Хигийн Их сургуулийн Шүдний тулгуур эдийн тэнхмүүд дээр эмнэл зүйн тохиолдлуудыг танилцуулсан гар дадлагатай 7 сургалтыг хийж шүдний тулгуур эдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч ажилсаар ирсэнийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ хугацаанд давхардсан тоогоор ойролцоогоор 600 гаруй шүдний эмчийг хамруулсан байна. 2009 оноос хойш өөрийн зардлаар ирж энэ салбарыг хөгжүүлэхэд санаа тавьж ирсэн БНСУ-ын Сеулийн Үндэсний Их Сургуулийн Шүдний тулгуур эдийн тэнхмийн Профессор KU Young-г 2016 онд НАСС-ийн Зочин Профессороор өргөмжилсөн.

Монгол Улсын Эрүүл Мэндийн сайдын 2016 оны 12-р сарын 15-ны өдрийн дугаар А/184 тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь Үндсэн мэргэшлийн сургалтын чиглэлд Боловсролын Олон Улсын стандарт ангиллын дагуу (ISCED) 0911-07 “Шүдний тулгуур эд судлал” буюу англи нэршил: Periodontics мэргэшлийг оруулснаар мэргэжлийн эмч бэлтгэх нөхцөл бүрдсэн. Түүнчлэн 2019 оны 9-р сарын 30-нд АШУҮИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрээр НАСС-ийн 7 дахь тэнхим болох “Шүдний тулгуур эд судлал, сувгийн эмчилгээний тэнхим” шинээр байгуулагдсан.

Монгол улсад шүдний тулгуур эдийн өвчлөл өндөр хэвээр байгаа бөгөөд эмчилгээний хувьд шүдний чулуу авах, буйл тайрахаар хязгаарлагдаж байгаа учраас шүдний тулгуур эдийн өвчнийг оношилж, эмчлэх, шүдний тулгуур эдийн өвчний улмаас алдагдсан хатуу болон зөөлөн эдийг мэс заслын болон мэс заслын бус аргаар нөхөн төлжүүлэн шүдийг хадгалж, зажлах үйлийг сэргээх эмч бэлтгэж эхлэх зайлшгүй шаардлагатай байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Шүдний тулгуур эдийн онолын болон эмнэл зүйн өндөр мэдлэг бүхий Шүдний тулгуур эдийн зонхилон тохиолдох өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч чаддаг, ялган оношилж, ШТЭ-ийн мэс заслын бус болон мэс заслын эмчилгээ хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга зүйг эзэмшсэн шүдний тулгуур эдийн эмчилгээний эмчийг (Periodontologist) боловсролын үндсэн зарчим олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухамсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын өндөр

мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа нотолгоонд суурилсан инноваци бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна.

ДӨРӨВ. ЦОГЦ ЧАДАМЖ

Чадамж бүхий шүдний их эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, мэргэжлийн тусламж үйлчилгээг бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Шүдний тулгуур эд судлалын эмч байх (Periodontologist)
2. Мэргэжлийн байх (professional)
3. Суралцагч байх (learner)
4. Харилцагч байх (communicator)
5. Хамтрагч байх (collaborator)
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (community health advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (leader)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Хөтөлбөр нь доорх зорилтыг биелүүлнэ.

1. **Шүдний тулгуур эд судлалын эмч байх** (Periodontologist)
 - Шүдний тулгуур эдийн эмгэгийн шинж тэмдгийг таньж, ялган оношлох
 - Өвчтөнөөс асуумж авч, мэргэжлийн үзлэг хийх, тухайн өвчтөний сэтгэл зүй, нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ хяналтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
 - Тухайн эмч өөрийн ажиллаж байгаа эмнэлгийн (орон нутаг, дүүргийн эмнэлэг, төрөлжсөн нэгдсэн эмнэлэг) түвшинд хийгдэх оношилгоо эмчилгээний гардан үйлдэл ажилбарын стандарт удирдажийг бүрэн эзэмшиж тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх
 - Өвчтөний хувийн нууцыг хадгалах
 - Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарах
 - Тухайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөц бололцоог бүрэн дайчилж өвчтөнд үзүүлэх мэргэжлийн тусламж үйлчилгээг шийдвэрлэх
 - Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл тайлан, бичиг баримтыг зохих журмын дагуу цаг тухайд нь хөтлөх
2. **Мэргэжлийн байх** (professional)
 - Тухайн эрүүл мэндийн байгууллагад мэргэлээрээ хувь нэмэр оруулах чин хүсэлтэй
 - Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
 - Хувь хүний онцлогыг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй хүндэтгэлтэй харьцах
3. **Суралцагч байх** (learner)
 - Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд хамрагддаг байх
 - Бие даан тасралтгүй суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг хэрэглэж дүн шинжилгээ хийх

- Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах
4. **Харилцагч байх** (communicator)
- Өвчтөний гэрбүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй зөв зохистой үг хэллэг хэрэглэн харьцах
 - Өвчтөнд ойлгомжтой үг хэллэг хэрэглэн шаардлагатай мэдээлэл өгөх
 - Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх
5. **Хамтрагч байх** (collaborator)
- Тухайн орон нутгийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож хамтран ажиллах
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах
6. **Эрүүл мэндийн зөвлөгч байх** (community health advocate)
- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах
 - Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх
7. **Зохион байгуулагч, манлайлагч байх** (leader)
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах
 - Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт үргэлжлэх нийт хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна. Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр Шүдний тулгуур эд судлалын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээнд нэгдсэн бусад байгууллага)-ын амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн тасаг, ариутгалын тасаг, нүүр амны мэс заслын, нүүр амны согог заслын, шүдний гажиг засал, шүдний сувгийн эмчилгээ, хурлын танхим, сургалтын танхимд сургалт явагдана.
- Хөтөлбөрийн зарим агуулгын явуулах хангалттай орчин бүрдүүгүй тохиолдолд тойролтуудын 30 хүртэлх хувийг эрүүл мэндийн бусад байгууллагыг түшиглэн явуулж болно.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг өвчтөн үзэх, гардан үйлдэлд сурах үйл ажиллагааг хангаж, сургалтын хөтөлбөр, мэргэжлийн багш, мэргэжлийн ном, сэтгүүл, сурах бичгээр хангагдсан номын сан, интернэтэд ажиллах бололцоо нөхцөлөөр хангаж сургалтын алба, тасаг боловсруулна.

- Сургалт явуулах үндсэн байгууллага ба сүлжээ эмнэлгийн тасаг, амбулатори дээр суралцаж ажиллах хугацаандаа эрүүл мэндийн байгууллагын сургалтын дотоод журмыг мөрдлөг болгоно.
- Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2. Зайлшгүй таньж мэдэх, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд ажлын байранд бие дааж тусламж үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналтан дор амбулатороор үйлчлүүлэгсдийн оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж туршлага хуримтлуулсан байна.

6.2.1. Өвчний шинж тэмдэг (signs and symptoms):

1. Буйлнаас цус гарах (gingival bleeding)
2. Буйлнаас идээ гарах (pus from gingival)
3. Буйл улайж хавдах (red swollen gum)
4. Буйл томрох (gingival hypertrophy)
5. Буйл шамрах (gingival recession)
6. Шүд сулрах (loose tooth)
7. Шүд хэт мэдрэгших (tooth hyperesthesia)
8. Буйл шүдний эмгэг хөндий үүсэх (periodontal pocket)
9. Буйлны хуурамч хөндий үүсэх (pseudopocket)
10. Амнаас эвгүй үнэр гарах (halitosis, malodor)
11. Хазаход хөндүүрлэх (painful chewing)
12. Буйл, шүд өвдөх (tender gum)
13. Шүд хазах явцад чичиргээнд орох (fremitus)
14. Халуурах (fever)
15. Буйл үхжих (gum necrosis)
16. түүшин яс үхжих (alveolar bone necrosis)
17. Буйланд цэврүүнцэр үүсэх (vesicula on the gum)
18. Буйл шархлах (gingival ulceration)
19. Булчирхай цочих (swollen lymph node)
20. Буйлны буглаа үүсэх (gingival abscess)
21. Шүдний тулгуур эдийн буглаа үүсэх (periodontal abscess)

6.2.2. Зайлшгүй суралцаж таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд

Биофилмээр үүсгэгдсэн буйлны цочмог үрэвсэл (Acute gingivitis plaque induced) K05.00

Биофилмээр үүсгэгдээгүй буйлны цочмог үрэвсэл (Acute gingivitis non-plaque induced) K05.01

Биофилмээр үүсгэгдсэн буйлны архаг үрэвсэл (Chronic gingivitis plaque induced) K05.10

Биофилмээр үүсгэгдээгүй буйлны архаг үрэвсэл (Chronic gingivitis non-plaque induced) K05.11

Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл–тодорхой бус (Aggressive periodontitis unspecified) K05.20

Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл – хэсгийн (Aggressive periodontitis, localized) K05.21

- 1 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл–хэсгийн -хөнгөн(Aggressive periodontitis, localized, slight)
- 2 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл –хэсгийн -дунд (Aggressive periodontitis, localized, moderate)
- 3 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл –хэсгийн–хүнд (Aggressive periodontitis, localized, severe)
- 9 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл –хэсгийн –тодорхой бус (Aggressive periodontitis, localized, unspecified)

Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл –тархмал (Aggressive periodontitis, generalized) K05.22

- 1 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл- тархмал –хөнгөн (Aggressive periodontitis, generalized, slight)
- 2 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл–тархмал–дунд (Aggressive periodontitis, generalized, moderate)
- 3 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл – тархмал – хүнд (Aggressive periodontitis, generalized, severe)
- 9 Шүдний тулгуур эдийн агрессив үрэвсэл – тархмал – тодорхой бус (Aggressive periodontitis, generalized, unspecified)

Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл K05.3

Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл тодорхой бус-(Chronic periodontitis, unspecified) K05.30

Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл хэсгийн-(Chronic periodontitis, localized) K05.31

- 1 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл хэсгийн –хөнгөн(Chronic periodontitis, localized, slight)
- 2 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл хэсгийн -дунд (Chronic periodontitis, localized, moderate)
- 3 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл -хэсгийн -хүнд (Chronic periodontitis, localized, severe)
- 9 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – хэсгийн - тодорхой бус (Chronic periodontitis, localized, unspecified severity)

Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – тархмал-(Chronic periodontitis, generalized) K05.32

- 1 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – тархмал – хөнгөн(Chronic periodontitis, generalized, slight)
- 2 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – тархмал - дунд (Chronic periodontitis, generalized, moderate)
- 3 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – тархмал - хүнд дунд (Chronic periodontitis, generalized, severe)
- 9 Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл – тархмал - тодорхой бус(Chronic periodontitis, generalized, unspecified)

Пародонтоз –(Periodontosis) K05.4

Шүдний тулгуур эдийн бусад өвчин- (Other periodontal diseases) K05.5

Шүдний тулгуур эдийн өвчин – тодорхой бус-(Periodontal disease, unspecified) K05.6

Буйлны шамралт-Gingival recession K06.0

Буйлны томролт-Gingival enlargement K06.1

Гэмтлээр үүсгэгдсэн буйлны шархлаа-(Gingival and edentulous alveolar ridge lesions associated with trauma) K06.2

Түүшин ясны хэвтээ шимэгдэл-(Horizontal alveolar bone loss) K06.3

Буйлны болон түүшин ясны бусад тодорхой эмгэгүүд-(Other specified disorders of gingiva and edentulous alveolar ridge) K06.8

Буйлны болон түүшин ясны бусад тодорхой бус эмгэгүүд-(Disorder of gingiva and edentulous alveolar ridge, unspecified) K06.9

Шүдний хэсэгчилсэн алдагдал-(Partial loss of teeth) K08.4

Зуултын эмгэг – анхдагч-(Primary occlusal trauma) K08.81

Зуултын эмгэг – хоёрдогч-(Secondary occlusal trauma). K08.82

(<https://www.icd10data.com/ICD10CM/Codes/K00-K95/K00-K14/K05->)

2017 оны Олон улсын Шүдний тулгуур эдийн холбооны ангилал

Эрхтэн тогтолцооны өвчний улмаас үүссэн шүдний тулгуур эдийн үрэвсэл

Буйл салстын гаж хөгжил

Буйлны цочмог үрэвсэл

Буйлны архаг үрэвсэл

Шүдний тулгуур эдийн цочмог үрэвсэл

Шүдний тулгуур эдийн архаг үрэвсэл

Буйлны хоргүй хавдар

Буйлны буглаа

Шүдний тулгуур эдийн буглаа

Буйлны шархлаат үхжилтэт үрэвсэл

Шүдний тулгуур эдийн шархлаат үхжилтэт үрэвсэл

Шүд буйлны үрэвсэл

Имплант орчмын салстын үрэвсэл

Периимплантит

Зуултын гэмтэл

6.2.3. Гардан үйлдлийн жагсаалт

1. Нүүр амны үзлэг хийх (Dental examination) – 8931

2. Буйл, түүшин ясны байдлыг оношлох арга (Diagnostic procedures of gum and alveoli) - 2419
3. Шүдний тулгуур эдийн өвчтэй хүнд шүд угаалт заах, хянах-Periodontal maintenance
4. Шүдний өнгөрийг тодорхойлох-Assessment of dental plaque
5. Шүдний чулууг тодорхойлох- Assessment of dental calculus
6. Зуултын гэмтэл тодорхойлох-Detect occlusal trauma
7. Хэсгийн ятроген шалтгаан арилгах(Remove iatrogenic local factors on periodontal health)
8. Буйлан дээрх чулууг цахилгаан баражаар авах-Ultrasonic Scaling
9. Сплинт хийх (dental wiring) – 9355
10. Буйлан дээрх, доорх чулууг гар баражаар авах-Scaling and root planing
11. Буйлны нөсөө арилгах (Gum depigmentation)
12. Буйл, түүшин ясанд зүслэг хийх (Incision of gum and alveolar bone) - 240
13. Буйл тайрах (Excision of lesion or tissue of gum) - 2431
14. Амны үүдэвч гүнзгийрүүлэх (Extension or deepening of buccolabial or lingual sulcus)-2491
15. Уруулын хөвч тайрч авах (Labial frenectomy)-2741
16. Уруулын хөвч тайрч уртасгах (Labial frenotomy)-2791
17. Буйланд оёдол тавих (Suture of laceration of gum)-2432
18. Далбан үүсгэж шүдний чулуу авах (Periodontal open flap debridement)
19. Түүшин яс хэлбэржүүлэх (Alveoloplasty) - 245
20. Түүшин ясны шимэгдлийг хиймэл ясаар нөхөх (Guided Tissue Regeneration-GTR)
21. Шүдний цөгц уртасгах- Crown lengthening
22. Буйлны буглаа нээх (Drainage of face and floor of mouth)-270
23. Шүдний тулгуур эдийн буглаа нээх- Periodontal Abscess Drainage
24. Шүдний тулгуур эдийн шарх цэгцлэх, оёдол тавих-Repair and suturing periodontal wound
25. Буйл салстад хэсгийн мэдээгүйжүүлэлт хийх- Application of local anesthesia on mucogingiva
26. Имплант хийх – (dental implant) -236
27. Буйлны шамралт засах (gingivoplasty) - 242
28. Буйл зузааруулах – (Other operations on gum) - 2439
29. Найдваргүй шүд авах (Dental extraction) - 2309
30. Трансплантаци хийх (Dental transplantation)
31. Реплантаци хийх (Implantation of tooth) - 235
32. Сурвалжийн оройг тайрах (apicoectomy) -2373
33. Сурвалж тайрах (Root amputation)
34. Сурвалж цөгцтэй тайрах (Tooth hemisection)

Онолын мэдлэг сайжруулах

Хэлэлцүүлэг – Journal review (1 сард 5-с дээш өгүүлэл, тойм)

- Резидент нь удирдагч багштай хамтран сургалтын болон шинжлэх ухааны сэтгүүлийг сонгон авч уншиж бэлтгээд хэлэлцүүлнэ

- Резидент нь өөрийн сонгож авсан өгүүллийг удирдагч болон бусад эмч нарт 15 минутын хугацаанд танилцуулан тайлбарлаж хэлэлцүүлнэ

Номын хэлэлцүүлэг – Book review (1 сард 2 удаа)

Нэгдүгээр дамжааны резидент эмч

- Journal of Periodontology and Implant sciences 2016 оноос хойш дугаар
- Medical Emergencies in the Dental Office 6th ed. Stanley F. Malamed
- “A color atlas of periodontology”, J.D. Strahan, I.M. Waite, Wolf Medical Publications

Тохиолдлын хэлэлцүүлэг – Case discussion (1 сард 1 удаа)

- Резидент эмч нь сургалтын эмнэлэгт өөрийн эмчилсэн, ажигласан, хагалгаа мэс ажилбарт нь оролцсон өвчтөний амбулатори болон тасагт байсан түүхийг бэлтгэнэ.
- Чухал бөгөөд зонхилон тохиолддог өвчний түүхийг шаардана
- Бүтэн түүхийг багтаана: Гол зовуур, өвчний түүх, бодит үзлэг, нэмэлт шинжилгээ, урьдчилсан оношийн таамаг, эмчилгээ, эмчилгээний үр дүн, тавиланг танилцуулах ба тухайн өвчний талаарх онолын мэдээллийг хүргэнэ.
- Бэлтгэсэн түүхийг 15 минутад багтаан бусад резидент эмч нарт танилцуулна.
- Хэлэлцүүлэг профессорын багийн ахлах болон профессор багшийн удирдлагад явагдана.

Төгсөлтийн тайлан хамгаалах хурал (Резидент эмч 1 эмнэл зүйн тохиолдол илтгэл)

- Төгсөх дамжааны резидент эмч нь өөрийн эмнэл зүйн тохиолдлуудаас шилдэг тохиолдлыг сонгож танилцуулна
- Сургалт эрхлэх байгууллагын эмнэл зүйн сургалт удирдах эрхтэй багш болон Шүдний тулгуур эдийн багш нарын удирдлагад хэлэлцүүлэгт оролцоно.
- Нэгдүгээр дамжааны резидент эмч чуулганы зохион байгуулалтын үйл ажиллагаанд зохицуулагч багшийн гаргасан хуваарийн дагуу заавал оролцоно.

Бусад хэлэлцүүлэг

- Нэг ба хоёрдугаар дамжааны резидент эмч нар шүдний тулгуур эдийн координатор багшийн удирдлага зөвшөөрлийн дагуу нэр хүндтэй профессор багш нар болон зөвлөх эмч нарын сургалт лекцэнд оролцоно.

Загвар 1

Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

№	Сургалтын хэлбэр	Резидент эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Удирдагч, хамтрагч
---	------------------	---------------------	---------------------------	-----------------------	-----------------	--------------------

1	ШТЭ-ийн үзлэг	4	8 цаг, 7 хоногт 3 удаа	АШУУИС-ийн НАСТЭ-ийн ШТЭ судлалын тасаг, НАМЗ-ын тасаг, НАСЗ-ын тасаг, НАГЗ-ын тасаг, Имплант, лазер эмчилгээ хийдэг бусад шүдний эмнэлгүүд	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, эмч
2	Хяналтын тойрон үзлэг	2	4 цаг, 7 хоногт 1 удаа		өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, эмч
3	Сургалтын тойрон үзлэг	2	1 цаг, 7 хоногт 4 удаа		өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, эмч
4	Гардан хийх үйлдэл	4	4 цаг, 7 хоногт 1 удаа		өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, эмч
5	Мэс засалд оролцох, мэс засал хийх	2	1 цаг, 7 хоногт 1 удаа		өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, эмч

Хяналтын тойрон үзлэг: Суралцагч эмч ШТЭ судлалын тасагт үйлчлүүлэхээр ирж байгаа өвчтөний зовуур болон хийгдэх нэмэлт шинжилгээний талаар эмнэл зүйн сургагч багш болон бусад эмчид танилцуулах зорилготой. Үүний тулд анх удаа үйлчлүүлэхээр ирсэн хүнийг угтан авч, бие даан асуумж цуглуулан, өвчний түүхтэй танилцан, өвчтөний биеийн байдлыг үнэлж, урьдчилсан оношийг дэвшүүлэн эмнэл зүйн сургагч багш болон эмчид танилцуулахад бэлдэнэ. Танилцуулгыг сургалтын өрөө зэрэг эмнэл зүйн бус өрөөнд хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг: Сургалтад тохиромжтой нэг өвчтөн сонгож, мэргэжлийн үзлэг шинжилгээ хийж, урьдчилсан онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө боловсруулан эмнэл зүйн сургагч багш болон хамтран суралцагч нарт танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэн байж болох хувилбарыг харилцан ярилцана.

Загвар 2

Танхимын сургалт (On-the-Job Training)

№	Аргачлал	Резидент эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Хамтрагч
1	Бие даалт	1	4 цаг, 7 хоногт 1 удаа	Номын сан, Сургалтын танхим	Ном сурах бичиг, цахим сэтгүүл, цахим ном, интернет	Суралцагч, хамтран суралцагч

2	Лекц	4 доошгүй	14 хоногт 1 удаа	Сургалтын танхим	РРТ	Зөвлөх эмч, профессор багш
3	Хэлэлцүүлэг	4 доошгүй	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Ном, сэтгүүл, өгүүлэл, цахим сэтгүүл, цахим ном	Эмнэл зүйн сургагч багш
4	Семинар	4 доошгүй	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Хэвлэлийн тойм	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08:30-12:30	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг	Сургалтын тойрон үзлэг
12.30-13:30	Цайны цаг				
13:30-17:30	Семинар	Лекц	Мэс засалд орох	Семинар	Хэлэлцүүлэг
	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Гардан үйлдэл	Амбулаторийн үзлэг	Бие даалт

6.3. Тойролтын хуваарь

Эмнэлзүйн тойролтууд	Хугацаа	Тойролт хийх эмнэлгүүд
Танилцах тойролт	2 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг, ариутгалын тасаг
Шүдний тулгуур эдийн эмчийн туслах	4 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Шүдний тулгуур эд судлалын суурь мэдлэг	22 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Шүдний чулуу авах арга	5 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Шүд эрүү нүүрний эрхтэнүүдийн дүрс оношлогоо	2 долоо хоног	Рентген тасаг

Оношилгоо, тавилан, эмчилгээний төлөвлөлт	5 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
ШТЭ-ийн эмчилгээний зарчим	6 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Нүүр амны согог заслын дадлага	2 долоо хоног	Нүүр амны согог заслын тасаг
Тулгуур эдийн өвчний үед сувгийн эмчилгээ хийх шаардлага	4 долоо хоног	Сувгийн эмчилгээний тасаг
Нүүр амны гажиг заслын дадлага	2 долоо хоног	Нүүр амны гажиг заслын тасаг
Нүүр амын мэс заслын дадлага	2 долоо хоног	Нүүр амны мэс заслын тасаг
ШТЭ-ийн мэс заслын эмчилгээний ойлголт	9 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Буйл салстын мэс засал	7 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Шүдний тулгуур эдийн өвчний хяналт	5 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг
Имплант эмчилгээ	5 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг, имплант хийдэг эмнэлгүүд
Лазер эмчилгээ, бичил мэс засал, цахилгаан мэс заслын ойлголт, ШТЭ-ийн эмчилгээний орчин үеийн ололт амжилт	6 долоо хоног	Нүүр амны тулгуур эд судлалын тасаг, Лазер хэрэглэдэг шүдний эмнэлгүүд
НИЙТ	88 долоо хоног	

6.4. Тойролтын агуулга

Танилцах тойролт (тойролт-1)

- Шүдний тулгуур эд судлалын тасгийн зохион байгуулалт, ажиллах зарчим, хагалгааны өрөөнд баримталж мөрдөх дэг журам
- Халдвар хамгаалал, асептик, антисептикийн онолын үндэс
- Гар халдваргүйжүүлэх, хагалгааны талбай халдваргүйжүүлэх, тусгаарлах арга
- Багаж ангилах, халдваргүйжүүлэх, ариутгах, хадгалах, ирлэх, хүлээж авах, хуваарилах

Шүдний тулгуур эдийн эмчийн туслах (тойролт-2)

- ШТЭ-ийн эдийн эмчид туслах
- Өвчтөн угтах, эмчилгээний цаг өгөх
- Зөвлөгөө өгөх
- ШТЭ-ийн үзлэгт бэлдэх
- Шүд угаах зөвлөгөө өгөх

Шүдний тулгуур эд судлалын суурь мэдлэг (тойролт-3)

- Нүүр амны анатом, гистологи
- ШТЭ-ийн патологи, микробиологи, иммунологи
- Өвдөлт, механизм
- ШТЭ-ийн эм судлал
- Судалгааны арга зүй
- Шүдний тулгуур эдийн өвчний эмгэг жам
- Шүдний тулгуур эдийн эмгэг судлал

Шүдний чулуу авах арга (тойролт-4)

- Шүдний чулуу авахад хэрэглэх багажны төрөл,
- хэрэглээ,
- шүдний чулуу авах, зарчим,
- шүдний янз бүрийн гадаргууд чулуу авах арга,
- чулууны багаж ирлэх арга

Шүд эрүү нүүрний эрхтэнүүдийн дүрс оношлогоо (тойролт-5)

- Нэг шүдний, дэлгэмэл, хазалтын зургууд дээр шүдний тулгуур эдийн эрүүл, эмгэг бүтцийг мэдэх,
- Ясны шимэгдэл, шүд сурвалжийн харьцаа, холбоосын зай, зуултын гэмтэл, бифуркаци, трифуркацийн эвдрэл таних
- Эрүүний үе ажиглах
- СВСТ-ын тухай ерөнхий ойлголт, ажиллах зарчим
- Хазалтын рентген зураг авах арга, анхаарах зүйлс

Оношилгоо, тавилан, эмчилгээний төлөвлөлт (тойролт-6)

- Эмнэл зүйн оношилгоо
- Рентген болон бусад оношилгооны аргууд
- Тавиланг тодорхойлох
- Эмчилгээний төлөвлөгөө
- Эрхтэн тогтолцооны өвчтэй хүмүүсийн ШТЭ-ийн эмчилгээ
- Өндөр настны ШТЭ-ийн эмчилгээ

Шүдний тулгуур эдийн эмчилгээний зарчим (тойролт-7)

- Шүдний гадаргууг бэлтгэх
- Өнгөрийн хяналт
- Нянгийн эсрэг болон бусад халваргүйжүүлэх бодисууд

- ШТЭ-ийн хурдан явцтай болон рефрактор үрэвсэл, Буйл, шүдний тулгуур эдийн үхжилтэт шархлаат үрэвслийн эмчилгээ
- ДОХ-ын өвчтэй хүмүүсийн эмчилгээ
- Цөгцийг хэлбэржүүлэх
- Шүдний тулгуур эдийн эмчилгээнд гажиг заслын асуудал
- Сплинт
- Нотолгоонд суурилсан шүдний тулгуур эдийн эмчилгээ

Нүүр амны согог заслын дадлага (тойролт-8)

- Нүүр амны согог заслын клиникийн бүтэц зохион байгуулалт
- Нүүр амны согог заслын эмчийн ажлын байр, тоноглол, түүнийг арчлах, хамгаалах, ажиллуулах зарчим
- Нүүр амны согогтой өвчтөн шинжлэх
- Шүдний цөгц, шүдний эгнээний согогтой өвчтөний үзлэгийн карт хөтлөх
- Хоршихуйн тухай ойлголт
- Амыг шүдэлбэрт бэлдэх
- Шүдэлбэрийг аманд суулгах, зөвлөгөө өгөх
- Шүдэлбэр эмчилгээний дараах давтан үзлэг хийх

Тулгуур эдийн өвчний үед сувгийн эмчилгээ хийх шаардлага (тойролт-9)

- Зөөлц, сурвалжийн үрэвслийн оношилгоо
- Төлөвлөгөө
- Сувгийн эмчилгээний үе шат
- Сувгийн эмчилгээ
- Шүдний тулгуур эдийн эвдрэл зөөлц-сурвалжийн үрэвсэл хавсарсан үеийн эмчилгээ

Нүүр амны гажиг заслын дадлага (тойролт-10)

- Нүүр амны гажиг заслын клиникийн бүтэц зохион байгуулалт
- Нүүр амны гажиг заслын эмчийн ажлын байр, тоноглол, түүнийг арчлах, хамгаалах, ажиллуулах зарчим
- Халдвар хамгаалалын дэглэм, эрүүл ахуйн шаардлага
- Сүүн шүдний болон холимог зуултын зүй тогтол
- Шүд эрүүний гажгийн ангилал (Энгль)
- Шүд эрүүний гажигтай өвчтний үзлэгийн карт бөглөх
- Шүд эрүүний гажигтай өвчтөнг шинжлэх аргууд
- Шүд эрүүний гажгийн үед эрүүний үений рентген зурганд дүн шинжилгээ хийх
- Авагддаг зэмсэг эмчилгээний ерөнхий зарчим
- Шүд эрүүний гажгаас урьдчилан сэргийлэх аргууд (буруу зуршил)

Нүүр амын мэс заслын дадлага (тойролт-11)

- Мэс заслын үе шат

- НА-ны мэс заслын ерөнхий зарчим
- Оёдлын төрөл, шархны цэгцлэлт
- На-ны мэс засалд хэрэглэх багажнууд
- Бүтэн болон хагас саатсан агт араа авах арга
- НА-ны буглааны төрлүүд, буглааг нээх, цэвэрлэх аргууд
- НА-ны хатиг мундас нээх, цэвэрлэх аргууд
- Резектив ясны мэс засал (сурвалжийн орой тайрах)
- Реконструктив ясны мэс засал
- НА-ны зөөлөн болон хатуу эдийн гэмтлийн төрлүүд, авах арга хэмжээнүүд
- Цус алдалтын үед авах арга хэмжээ
- Шүлсний булчирхайн үрэвлийн үед авах арга хэмжээ
- Мэдээ алдуулалтын хүндрэлийн үед авах арга хэмжээ

ШТЭ-ийн мэс заслын эмчилгээний ойлголт (тойролт-12)

- Мэс заслын үе шат
- ШТЭ-ийн мэс заслын ерөнхий зарчим
- Буйл тайрах
- ШТЭ-ийн далбангийн төрөл
- Резектив ясны мэс засал
- Реконструктив ясны мэс засал
- Фуркаци хамарсан үрэвслийн эмчилгээ, сувгийн эмчилгээ хавсарсан эмчилгээ

Буйл салстын мэс засал (тойролт-13)

- Буйлны томролт,
- Буйл томрох шалтгаан,
- Буйлны хавдар төст өөрчлөлтүүдийн эмнэл зүй, гистологи, ялгах онош,
- Буйлны нөсөө

Шүдний тулгуур эдийн өвчний хяналт (тойролт-14)

- ШТЭ-ийн өвчний хяналтанд авах шаардлага
- Хяналтанд авах арга

Имплант эмчилгээ (тойролт-15)

- Имплантын биологийн, эмнэл зүйн, мэс заслын зүй тогтол
- Оношилгоо, төлөвлөгөө
- Имплантын мэс засал
- Имплантын согог засал
- Имплант амжилтгүй болох, авах арга хэмжээ
- Периимплант, авах арга хэмжээ

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВӨЛГӨӨ

7.1. Сургалт эрхлэх байгууллага нь ажлын байрны сургалтыг удирдан явуулах эмнэлзүйн сургагч багш нарыг томилон хуваарилна. Сургалтын явц, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хяналт тавих сургалт хариуцагч (mentor)-ыг сургалт эрхлэх

байгууллага томилон ажиллуулна. Сургалт хариуцагч нь сар бүр нэг удаа тогтмол уулзалт зохион байгуулж суралцагч эмч нартай мэдээлэл солилцож үнэлгээтэй танилцана.

- 7.2. Тойролт бүрт суралцагч эмчийг сүлжээнд нэгдсэн эмнэлэгүүдэд илгээж тойролтын хугацаанд хэрэгжүүлэх зорилтуудыг танилцуулна. Тойролт дуусахад тойролт удирдсан багштай ярилцлага хийж, сургалтын үнэлгээ, зөвөлгөө авна
- 7.3. Үнэлгээний арга нь сургалтын явцын үнэлгээ, төгсөлтийн шалгалт гэсэн хоёр хэлбэрээр хийгдэнэ.
 - Шүдний тулгуур эд судлалын мэргэшигч эмч сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд Шүдний тулгуур эд судлалын үндсэн мэргэшлийн диплом олгоно.
 - Явцын буюу ажлын байранд суурилсан үнэлгээ нь дараах аргуудаар явагдана. Явцын үнэлгээ нь нийт үнэлгээний 80-аас доошгүй хувийг эзэлнэ.

Ажлын байранд суурилсан үнэлгээ

Workplace-based assessment-360 хэмийн үнэлгээ (360 Degree assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн (professional) байх, манлайлагч (leader) байх чадамжийг үнэлэхэд ашиглана. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвөлгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

Mini-CEX Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх шинж тэмдгүүдээс 5-аас доошгүй үйлдэл бүрд 3-аас доошгүй удаа нийт 15-аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct observation of procedural skills. DOPS):

Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 35 үйлдлээс 20-аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэлзүйн удирдагч багш нотолсон үнэлгээ. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэн эргэн зөвөлгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

- 7.4. Үнэлгээний дүнг хянах. Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэлзүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ. Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.
- 7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-CEX, DOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй шинж тэмдэг, өвчний тохиолдол,

гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу ирц, сургалтын ирц хангалтгүй бол тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх 21 шинж тэмдэгээс 2 жилийн хугацаанд 21-иос доошгүйг оношилж, эмчилж туршлага хуримтлуулсан байна.
- “Шүдний тулгуур эд судлал” үндсэн мэргэшлийн сургалтын тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 30-иас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- Зайлшгүй суралцах 35 гардан үйлдлээс 2 жилийн хугацаанд 80%-иас цөөнгүйг хийж гүйцэтгэн туршлага хуримтлуулсан байна

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

8.1. Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалт эрхлэх байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлэгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, Эрүү нүүрний мэс заслын тасаг, сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.
- Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлэгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага доор ажиллана
- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2. Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... он.....сар.....

Суралцагч эмчийн нэр.....

Үнэлгээ хийгч: () эмнэлзүйн сургагч багш () сувилагч () бусад

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноо тавина уу.

Тухайн асуултад үнэлгээ авах боломжгүй бол 0

Тухайн асуултыг 19% биелүүлсэн бол 1;

20-49% биелүүлсэн бол 2;

50-79% биелүүлсэн бол 3;

80-аас дээш биелүүлсэн бол 4 гэсэн үнэлгээ өгнө.

№	Үнэлэх үзүүлэлт	Дүн				
1	Үйлчлүүлэгч, гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	0	1	2	3	4
2	Эмнэлэгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг	0	1	2	3	4
3	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	0	1	2	3	4
4	Өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэр гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	0	1	2	3	4
5	Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	0	1	2	3	4
6	Өөрийн эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт, бусад боломжийг алдалгүй ашигладаг	0	1	2	3	4
7	Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	0	1	2	3	4
8	Бусад эмнэлгийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
9	Эмнэлэг доторх эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг	0	1	2	3	4
10	Ажиллаж байгаа эмнэлгийн доторх тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4
11	Үйлчлэх хүрээний болон орон нутгийн тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	0	1	2	3	4

1 эсвэл 4 оноо өгсөн бол шалтгаанаа бичнэ үү

1.	
2.	

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр..... Үнэлэгчийн нэр.....

Сургалт эрхлэх байгууллага: нэгж

Өвчтөний нас эр эм

Өвчтөний зовиур: Шинж тэмдэг (signs and symptoms)

1.буйлнаас цус гарах, 2. буйлнаас идээ гарах, 3. буйл улайж хавдах, 4. буйл томрох, 5. буйл шамрах, 6.шүд сулрах, 7. шүд хэт мэдрэгших, 8. буйл шүдний эмгэг хөндий үүсэх, 9. амнаас эвгүй үнэр гарах, 10. хазахад хөндүүрлэх, 11. буйл, шүд өвдөх, 12. шүд хазах явцад чичиргээнд орох, 13. халуурах, 14. бие тавгүйрхэх, 15. буйл үхжих, 16. түүшин яс үхжих, 17. буйланд цэврүүнцэр үүсэх, 18. буйл шархлах, 19. булчирхай чочих 20. Буйлны буглаа үүсэх 21. Шүдний тулгуур эдийн буглаа үүсэх

Сургалтын явцад суралцагч эмч ямар түвшинд байгааг өөрийн ажигласнаар үнэлнэ үү				
№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
1	Өвчний өгүүлэмж авах			
2	Бодит үзлэг			
3	Оношилгоо, эмчилгээний менежмент			
4	Харилцааны ур чадвар			
5	Эмнэл зүйн ерөнхий чадвар			
Сайн талууд		Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө		Бусад санад

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг..... Суралцагчийн гарын үсэг.....

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд

Өвчний өгүүлэмж авах	Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг Өвчтөнийг бүрэн ойлгож, тодорхой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Оношилгоо эмчилгээний менежмент	Зөв онош тавьдаг Оношилгоо эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг

	Тохирсон эмчилгээ эхлүүлдэг Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг
Харилцааны ур чадвар	Өвчтөн түүний гэр бүл, асран хамгаалагч хүнийг сайн сонсдог Тэдний зовинолыг хуваалцаж хүндэтгэлтэй ханддаг Тэдэнтэй эелдэг харилцаж, энгийн үг хэллэг хэрэглэн зөвөлгөө өгдөг
Эмнэлзүйн ур чадвар	Системтэй, харилцан уялдаатай арга замыг сонгодог Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг “Би гэр бүлийнхээ нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна”

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр: _____ ☐ R1 ☐ R2

Үнэлгээ хийгдсэн тасаг: ☐ Тасаг ☐ Бусад _____

Тухайн жилийн үнэлгээний дугаар: ☐ 1 ☐ 2 ☐ 3 ☐ 4

Өвчтөн: _____ нас _____ хүйс ☐ Эр ☐ Эм Регистрийн дугаар _____

Үнэлгээний төрөл: ☐ Анхан ☐ Давтан ☐ Төлөвлөгөөт ☐ Яаралтай

Гардан үйлдлийн зэрэг: ☐ Хөнгөн ☐ Дунд ☐ Хүнд

Үнэлгээний зорилго: ☐ Судалгаа ☐ Оношилгоо ☐ Эмчилгээ ☐ Бусад

Гардан үйлдэл: ☐ Нүүр амны үзлэг хийх ☐ Өвчний карт хөтлөх ☐ Рентген зураг унших
☐ Хэсгийн ятроген шалтгаан арилгах ☐ Оёдол тавих ☐ Буйлан дээрх чулуу авах ☐
☐ Буйлан доорх чулуу авах ☐ Буйл тайрах ☐ Амны үүдэвч гүнзгийрүүлэх ☐ Уруулын хөвч
☐ тайрч уртасгах ☐ Чиг тавих ☐ Түүшин яс хэлбэржүүлэх ☐ Түүшин ясны шимэгдлийг
☐ хиймэл ясаар нөхөх ☐ Шүдний цөгц уртасгах ☐ Шүдний имплант суулгах ☐ Буйлны
☐ шамралт засах ☐ Буйл зузаатгах ☐ Буйлны нөсөө арилгах ☐ Хавдраас эд, эсийн
☐ шинжилгээ авах ☐ Жижиг хоргүй хавдар авах ☐ Буглаа нээх ☐ Шарх цэгцлэх ☐
☐ Найдваргүй шүд авах ☐ Сурвалжийн оройг тайрах ☐ Сурвалж цөгцтэй тайрах ☐
☐ Трансплантаци хийх ☐ Реплантаци хийх ☐ Шүд угаалт заах, хянах ☐ _____

Өнөөг хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

Үнэлгээ хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: X

	Шалгуур	Хангалтг	Сайжруул	Хангалтт	Үнэлгээ
--	---------	----------	----------	----------	---------

№		үй			ах			ай			шаардлагаг үй
		1	2	3	4	5	6	7	8	9	
1	Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэддэг										
2	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг /өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг										
3	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлдэг										
4	Өвчтөний аюулгүй байдлыг хангадаг										
5	Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг										
6	Гардан үйлдлийг арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэдэг										
7	Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг										
8	Үйлдлийн дараахь менежментийг зохистой хангадаг										
9	Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага										
10	Үйлдлийн эмх цэгцийг хангадаг										
11	Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг										
13	Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар										

Зөвлөмж:

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд:

Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө:
Суралцагч эмчид өгөх эцсийн санал (нэгийг сонгох): ☐ Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, чадвар хангалтгүй ☐ Сургагч багшийн хяналтанд үйлдлийг хийх /хянах түвшинг сургагч багш шийдвэрлэнэ/ ☐ Суралцагч эмч үйлдлийг бие даан хийх боломжтой ☐ Суралцагч эмч энэхүү үйлдлийг бусдад заах/бусдыг хянах боломжтой
Суралцагч эмчид өгөх БУСАД санал:

DOPS үнэлгээ хийсэн хугацаа: _____ /мин/. Зөвлөгөө өгсөн хугацаа _____ /мин/

DOPS үнэлгээ хийсэн **БАГШИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

DOPS -р үнэлүүлсэн **СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

Багшийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Санамж:

САНАМЖ:	“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт
Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэдэх	• Сургагч багшид үйлдлийн заалт, эсрэг заалт, холбогдох морфологи анатомийн бүтэц, үйлдлийн үе шат, үйлдлийг гүйцэтгэх аргачлал, хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн заалт, эсрэг заалт, гаж нөлөө, болзошгүй эрсдэл, хүндрэлийн үеийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй, бүрэн тайлбарлаж чаддаг.
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл /зөвшөөрлийн хуудас авах	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид үйлдлийн талаар бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй, ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглан зохих тайлбарыг өгдөг. • Өвчтөн үйлдлээс айсан, сэтгэл нь тогтворгүй, түгшсэн тохиолдолд зовнилыг ойлгож, хуваалцаж, хүндэтгэлтэй, тэвчээртэй ханддаг, сонирхсон асуултанд оновчтой хариулдаг. • Зөвшөөрлийн хуудас бөглөхөөс өмнө өвчтөн нь гардан үйлдлийн талаар зохих ойлголттой байгаа талаар нягталдаг. • Өвчтөнд итгэл, үнэмшил төрүүлдэг. • Өвчтөнөөс шаардлагатай ажилбарт зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг.
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлэх	• Гардан үйлдлийг гүйцэтгэх төлөвлөгөөтөй. • Өвчтөний сэтгэл санаа, тайван байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэдэг. • Ажилбарын өмнөх хяналтын хуудас бөглөдөг, ажилбарын явц болон ажилбарын дараахь хяналтын хуудас, бичиг баримтыг бэлтгэдэг. • Гардан үйлдэлд шаардлагатай хувцас, өмсгөлийг бэлтгэдэг. • Үйлдлийг гүйцэтгэхэд найрсаг, ээлтэй, дулаан, байгалийн гэрэлтэй, цэвэр орчин бүрдүүлдэг.
Өвчтөний аюулгүй байдлыг хангах	• Гардан үйлдэл хийгдэх өвчтөний овог, нэр, регистрийн дугаар болон бусад аргуудаар танин тодруулдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд хэрэглэх/хэрэглэж болзошгүй тайвшруулах, мэдээ алдуулах эм, тарианы нэр, тун, хэрэглэх арга зэрэг чанар, аюулгүй байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд зөв зүү, тариурыг сонгож нягталдаг, чанар, аюулгүй байдлыг хангадаг.
Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэх	• Ариун бээлийг зөв задалж өмсөж, тайлдаг. • Ариун салфетка, ариун хөвөн бөмбөлөг, нэг удаагийн зүү, тариуртай зөв харьцдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай халдваргүйжүүлэх уусмалыг зөв ашигладаг. • Үйлдлийн талбайг зөв ариутгадаг. • Хурц үзүүртэй зүү, эмнэлгийн хэрэгслийг зөв ашиглаж устгадаг.

Гардан үйлдлийн арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэх	• Гардан үйлдлийн стандарт, протоколыг чанд мөрддөг. • Гардан үйлдлийг өөртөө итгэлтэй, чадварлаг гүйцэтгэдэг. • Зааварчилгааг тод, чанга дуугаар, ойлгомжтой өгдөг. • Зүү, тариур, тоног төхөөрөмжийг чадамгай ашигладаг. • Цус алдах болон бусад эрсдлээс сэргийлдэг.
Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед тусламж дуудах	• Үйлдэл амжилтгүй байгааг өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сандарч тэвдэлгүй, зөв зохистой ойлгуулж мэдээлдэг. • Үйлдэл амжилтгүй гүйцэтгэсэнээ хүлээн зөвшөөрдөг. • Өвчтөн болон ажилчидтай тайван, зохистой харьцдаг. • Гардан үйлдлийг илүү сайн гүйцэтгэхэд бусдын тусламжийг хүсэж чаддаг. • Цаашид илүү амжилттай суралцах шаардлагатайг ухамсарладаг.
Үйлдлийн дараахь менежментыг зохистой хангах	• Суралцагч эмч нь гүйцэтгэсэн гардан үйлдэлд бодит үнэлгээ дүгнэлтийг өгч чаддаг. • Үйлдлийн дараахь эмчилгээ, асаргаа сувилгаа, халдвар хяналтын зөвлөмжийг өвчтөн болон эмнэлгийн ажилчдад амаар болон бичгээр зөв өгдөг.
Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог, зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг, эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг. • Эмнэлгийн ажилчидтай хүндэтгэлтэй, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж харьцдаг. • Хүвь хүний нууцыг чанд сахидаг.
Үйлдлийн эмх цэгцийг хангах	• Гардан үйлдлийн бүх үе шат нь тайван, эмх цэгцтэй, дэс дараатай гүйцэтгэдэг
Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд нь хөтлөх	• Гардан үйлдлийг зохих журам, зааврын дагуу баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтын огноо, цаг, үг, өгүүлбэрийг тодорхой, гаргацтай бичдэг. • Гардан үйлдэл гүйцэтгэсэн суралцагч эмч нь нэр, гарын үсгээ тодорхой, гаргац сайтай баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтыг сургагч багшаар баталгаажуулдаг.
Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар	• Өвчтөний аюулгүй байдлыг үйлдлийн бүх үе шатанд тасралтгүй хангадаг. • Гардан үйлдэл гүйцэтгэх мэдлэг хангалттай. • Гардан үйлдлийн ур чадвар хангалттай. • Гардан үйлдлийн үед гаргах шийдвэр, зааварчилгаа нь зөв. • Холбогдох тоног төхөөрөмж, нөөцийг зөв, зохистой ашигладаг.

НОМ ЗҮЙ

1. Шүдний тулгуур эд сувгийн эмчилгээ. Сурах бичиг. Б. Баярчимэг, П. Оюун-Энх, Х. Оюунхишиг 2021
2. Шүдний тулгуур эд, сувгийн эмчилгээний гарын авлага П. Оюун-Энх, Б. Баярчимэг, Х. Оюунхишиг 2020 он
3. ШТЭ-ийн өвчний чиглэлээр хэвлэгдсэн эмнэл зүйн үр дүнгүүд 2018 он
4. Journal of Periodontology and Implant sciences 2016 оноос хойш дугаар
5. Handbook of Local Anesthesia 6th ed. Stanley F. Malamed
6. Medical Emergencies in the Dental Office 6th ed. Stanley F. Malamed
7. Panoramic Radiology Allan G. Farman
8. "A color atlas of periodontology", J.D. Strahan, I.M. Waite, Wolf Medical Publications